

ХЯТАДЫН ХИЛИЙН БОДЛОГО, ХИЛ ОРЧМЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА МАНАЙ УЛСЫН ХИЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГОД НӨЛӨӨЛӨХ НЬ

*Н.Ариунгуа**

БНХАУ-ын гадаад эдийн засгийн стратеги нь бусад орныхтой нэгэн адил глобалчлал, эдийн засгийн интеграчлалын хүрээнд бүрэлдэн бий болохын зэрэгцээ сүүлийн үед чиглэл, зорилго нь улам бүр тодорхой болж байна. Юуны түрүүнд Хятад улс бүс нутгийн хэмжээнд өөрийн нөлөөг бэхжүүлэх гадаад эдийн засгийн идэвхтэй бодлого хэрэгжүүлж байгаа бөгөөд Зүүн Азийг өөрийн нөлөөний хүрээ мөн хэмээн шууд зарлаж үүнийгээ АНУ-аар хүлээн зөвшөөрүүлэхийг оролдож байна. Хятадын үндэсний эдийн засаг хэмээх ойлголт нь БНХАУ-ын нутаг дэвсгэрээр хязгаарлагдахгүй болж, хятад хүний /диаспора/ бизнесийн үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн орчинг мөн хамрах хандлага гарч ирж байгааг гадны судлаачид тэмдэглэж байна.

Хятад улс “гадагшаа хандах”, “гадагшаа чиглэсэн” бодлого хэрэгжүүлэх болж энэхүү бодлогынхоо хүрээнд их хэмжээний хөдөлмөрийн хүчийг экспортлох бөгөөд гадаадад ажиллаж буй бүх хятад иргэд болон Хятад улсын бизнесийн эрх ашгийг тууштай хамгаалахаа хатуу мэдэгдэж байна. Нэг үгээр хэлбэл, урьд Хятадын гадаад бодлого нь дотоодлоо шинэчлэл хийх таатай гадаад орчинг бүрдүүлэхэд чиглэгдэж байсан бол өнөөдөр Хятад улс гадаад улс төр, эдийн засаг, үндэсний аюулгүй байдлын идэвхтэй бодлого хэрэгжүүлж эхлээд байна. Хятадын эдийн засгийн үйл ажиллагаа ийнхүү идэвхжсэн нь түүхий эдийн хэрэгцээ нь огцом өссөн, орчин үеийн дэвшилтэт технологи, техник олж авах, бүтээгдэхүүнээ борлуулах шинэ зах зээлийн төлөө тэмцлээр тайлбарлагдах юм.

Хятадын гадаад стратегийн энэхүү өөрчлөлт нь Монгол Улсын талаар баримтлах бодлого, тухайлбал хилийн бодлого, хил орчмын хамтын ажиллагаанд тусгалаа олох нь мэдээж.

Хятад улс хилийн худалдаа, хил орчмын хамтын ажиллагаанд маш их ач холбогдол өгч улсаас их хэмжээний хөрөнгө мөнгө гаргаж байгаа бөгөөд зөв, оновчтой зохион байгуулах нөхцөлд нэмэлт орлого олж авах тун боломжийн хэлбэр хэмээн үзэж байна. Хятад улс энэ чиглэлд сүүлийн жилүүдэд багагүй амжилт олж байгааг хөрш зэргэлдээ

*Н.Ариунгуа - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

орнуудтай хийж буй хилийн худалдааны байдлаас харж болох юм. Монголтой хийж буй хилийн худалдаа ч Хятадын талд маш ашигтай хэлбэрээр явагдаж ирсэн билээ.

Монгол-Хятадын хилийн худалдаа нь хоёр орны эдийн засаг зах зээлд шилжиж эхэлсэнтэй холбоотойгоор идэвхжиж, хятадын хямд төсөр бараа, монголчуудын худалдан авах чадвар доогуур байгаа өнөөгийн нөхцөлд Монголын зах зээлд маш түргэн идээшин зохицож ирэв. Хятадын бараа нь монголчуудын наад захын бараа таваар, хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг хангаж, харин монголчуудын хийж буй арилжаа наймаа нь Хятадын хил орчмын нутгийн эдийн засгийн хөгжлийг түргэсгэж, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх хүчин зүйл болж байна. Үүнийг ч Хятадын тал хүлээн зөвшөөрч байгаа юм. Ийнхүү Монголын экспортын бааз сулаас хамааран Монголын хувьд хилийн худалдааны ашиггүй бүтэц бий болоод байна. Өөрөөр хэлбэл түүхий эдээ хүнсний бүтээгдэхүүнээр сольж байгаа нь зөвхөн манай улсад тохиолдож байгаа зүйл биш, мөн Орос зэрэг хөрш зэргэлдээ орнуудтай хийж буй Хятад улсын худалдаанд ажиглагдаж байна. Энэ нь Хятадын талын буруу биш бөгөөд харин ч манай улс дотоодын үйлдвэрлэлээ сэргээж экспортын баазаа өргөтгөх шаардлагатайг харуулж байгаа юм.

Ийнхүү манай орны хувьд бүрэлдэн тогтсон худалдааны таатай бус нөхцөлд Хятад улсын гадаад эдийн засгийн бодлого улам эрчимжиж байгаа билээ. Үүнтэй холбоотой Монгол-Хятадын худалдаа, түүн дотроо хилийн худалдаа, хамтын ажиллагаанд шинэ нөхцөл байдал үүсч болзошгүй болоод байна. Үүнд: 1. Хятад улс Дэлхийн Худалдааны Байгууллагад элсч, Хятадын засгийн газраас дотоодын зах зээлээ хамгаалах зорилгоор үйлдвэрүүддээ санхүүгийн дэмжлэг үзүүлж байсныг зогсоосноор хятадын эд бараа, ялангуяа хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний өөрийн өртөг өсөн нэмэгдэж, улмаар манайд нийлүүлдэг хятадын барааны үнэ огцом өсөх хандлагатай байна. 2. Хятад улс хөрш зэргэлдээ орнуудтай хийж буй худалдаа бараа солилцооны үйл ажиллагаагаа тухайн орнуудын нутаг дэвсгэр рүү шилжүүлж бизнесийн санаачилгыг гартаа авах хандлагатай байна. 3. Гадагшаа чиглэсэн Хятадын гадаад эдийн засгийн бодлого нь эдийн засгийн маш идэвхтэй үйл ажиллагааг шаардах ба үүний дагуу Монгол руу маш олон тооны хятад иргэд бизнесийн шугамаар нэвтрэн орж ирэх бөгөөд шууд хил залгаа Монгол Улс үүнээс яавч зайлж чадахгүй юм. Тэр тусмаа зүүн хойд хятадын ажилгүйчүүдийн тоо 7-8 сая /1994 оны байдлаар/ хүрээд

байгаа бөгөөд энэ тоо улам өсөх хандлагатай байна. Иймээс манай улс үүнд бэлэн байж олон улсын хүн амын шилжих хөдөлгөөний (миграци) талаар хууль тогтоол гаргах шаардлагатай мэт. 4. Цаашид хил орчмын худалдаа улам өргөжих худалдааны чөлөөт бүс зэрэг хамтын ажиллагааны шинэ хэлбэрт орох нөхцөлд манай талаас маш нарийн зохион байгуулалт шаардагдах бололтой. Манай улстай арилжаа наймаа хийж буй хятадын худалдаачид маш нарийн зохион байгуулалттай, хоорондоо мэдээлэл хурдан солилцдог, монголчуудын эрэлт хэрэгцээг сайн мэдэрч түүний дагуу түргэн шуурхай үйл ажиллагаагаа явуулдаг давуу талтай. Гэтэл манай тал зохион байгуулалтын хувьд дутуу дулимаг байгаа бөгөөд наад захын жишээ гэхэд л хилийн боомтууд болох Гашуун сухайт, Бургастай, Шивээ Хүрэн зэрэг боомтын гаалийн үйл ажиллагаа хөрөнгө мөнгө хийгээд хариуцлагагүйгээс болж хангалтгүй ажиллаж, хятад наймаачид гаалийн татварыг завшиж байгаа гэх мэт ноцтой дутагдлыг дурьдаж болно. Нөгөө талаас Хятадын зах зээлийн талаархи мэдээлэл одоо хүртэл монголчуудын хувьд хаалттай байгаа бөгөөд хятадын наймаачид үүнийгээ чандлан хамгаалдаг нь худалдааны аргыг сайн эзэмшсэнийх бизээ. Ер нь харилцан ашигтай байх үүднээс хил орчмын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг зохицуулах хоёр талын зөвлөл байгуулах зэргээр хилийн худалдааг аль болохоор өгөөжтэй, үр дүнтэй болгож, улсын төсөв санхүүд нэмэлт орлого оруулдаг энэхүү худалдааны хэлбэрийг Хятад улсын туршлагаар маш сайн ашиглах шаардлагатай мэт.

Хятад улс алслагдсан хязгаар нутаг хийгээд хил орчмын бүс нутгуудад шинэчлэлийн бодлого хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд өнөөдөр тэрхүү бодлого нь улам эрчимжиж байна. Хятадын засгийн газраас 1992 оноос хил орчмын 13 хотыг нээлттэй болгов. Тухайлбал: Манжуур, Эрээн /ӨМӨЗО/, Суйфэн, Хэйхэ /Хэйлунцзян/, Хунчунь /Цилин муж/, Болэ, Инин /СУАР/, Хэкоу, Ваньцзин, Жуйли /Юньнань муж/, Пинсян, Дунсин /Гуанси-Чжуаны автономит район/ зэрэг юм. Мөн хилийн болон автономит район хийгээд далайн эрэг хавийн мужуудын засаг захиргааны 7 төвийг нээлттэй болгосон байна. Үүнд: Наньнин, Куньмин, Урумчи, Хөх хот, Харбин, Чаньчунь, Шицзячжуан зэрэг болно. Хятадын Төрийн Зөвлөлөөс гаргасан тогтоолын дагуу хил орчмын нээлттэй 13 хотод эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах эрх олгож улмаар далайн эрэг хавийн бүс нутгийн эдийн засгийн онцгой бүсэд олгодог хөнгөлөлттэй бодлого хэрэгжих болжээ.

Чингэхдээ Хятад улс хил орчмын бүс нутагт худалдааны чөлөөт бүсийг байгуулах сонирхол их байгаа бөгөөд эдийн засгийн чөлөөт бүсийн энэхүү хэлбэр нь Хятад улсын тооцоолж байгаагаар илүү үр ашигтай ажээ. Худалдааны чөлөөт бүсийн үйл ажиллагаа, аж үйлдвэрийн бүтэц, татварын хөнгөлөлтийн талаас нь авч үзэх юм бол гол нь худалдаа, дараа нь үйлдвэрлэлийг нээлттэй болгож, гадаадын бүх бараа бүтээгдэхүүнийг буюу дийлэнхийг экспорт, импортын гаалийн татвараас чөлөөлөх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт хийх замаар боловсруулалтын чиглэлийн үйлдвэр байгуулах, гадаадын хөрөнгө оруулагчдад худалдаа, санхүү, аялал жуулчлал эрхлэхийг зөвшөөрдөг байна. Одоогоор энэхүү хэлбэрийн эдийн засгийн чөлөөт бүсүүд гол төлөв хөгжингүй орнуудад байгуулагдсан байдаг.

Хятадын засгийн газар ойрын ирээдүйд хилийн боомт хот болох Эрээний орчимд худалдааны чөлөөт бүс байгуулахаар төлөвлөж үндэслэл гаргах шатандаа ороод байгаа бөгөөд чингэхдээ манай улстай хил дамнасан худалдааны чөлөөт бүс байгуулах сонирхол давамгайлж байгаа юм. Үүнийгээ Хятадын тал хилийн боомтууд тухайн шаардлагад нийцэж байгаа, зах зээлийн ижил төстэй тал, нөөц баялгийн хүчин зүйлийг ашиглах зэргийг харгалзаж, хоёр тал хэлэлцэн тохирсоны үндсэн дээр цаг хугацааны хувьд нэгэн зэрэг хил дамнасан худалдааны чөлөөт бүс байгуулах саналтай байна. Нөгөөтэйгүүр Хятад улс нь Монгол-Хятадын хил орчмын худалдаа, хамтын ажиллагааны өнөөгийн түвшинг хангалтгүй, чамлалттай хэмээн үзэж зөвхөн хилийн худалдаа, хилийн барилга байгууламж барих гэрээ, хөдөлмөрийн гэрээ, хилийн аялал жуулчлал зэргээр хязгаарлагдаж байгаа нь хоёр орны хооронд хөрөнгө мөнгө, техник, хөдөлмөрийн хүч, зах зээл, ашигт малтмал, үйлдвэрлэлийн бүтцийн өсөлтийн талаар бие биенээ нөхөх асар их боломжийг гүйцэд ашиглаж чадахгүй байна гэж үзэж байна.

Хятад улс нь эдийн засгийн чөлөөт бүс байгуулах 20 гаруй жилийн арвин туршлагатай бөгөөд энэ талаар маш их амжилт олсоныг Хятадын зүүн өмнөд хэсгийн хийгээд Шанхайн орчмын Пудуны эдийн засгийн нээлттэй бүсүүдийн хөгжлийн байдлаас харж болох юм. Чингэхдээ Хятадын засгийн газраас эдгээр чөлөөт бүсүүдийг байгуулахын тулд эзгүй ээлүүд газар зам харилцаа, холбоо байгуулах, орон сууц, албан газар, нийгмийн талын бүхий л үйлчилгээг бий болгоход санхүүжилтийн 80 хувийг бие даан гаргасан бөгөөд чухамхүү тэгэж байж гадны хөрөнгө оруулагчдыг татаж чадсан бөгөөд тэдгээр нь зөвхөн бэлэн юман дээр ирж үйлдвэрээ байгуулсан байдаг. Иймээс энэхүү туршлагаас

харахад, гадны хөрөнгө оруулагчид нь эзгүй тал газрыг засан тохижуулж аж ахуйг нь хөгжүүлэхээр улайран тэмүүлж байгаа гэсэн ойлголт бидний дунд байгаа нь гэнэн бөгөөд дэлхийн практикт нийцэхгүй зүйл юм.

Эрээний орчимд байгуулахаар төлөвлөж байгаа чөлөөт худалдааны бүс нь Хятадын баруун бүсийг нээж хөгжүүлэх стратегийн нэг хэсэг юм. Энэхүү стратегийн хүрээнд Хятад улс баруун бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг Зүүн Өмнөд Хятадын хөгжлийн түвшинд хүргэх бодлого хэрэгжүүлэхээр төлөвлөж, Хятадын эдийн засгийн бүсүүдийг хөгжлийн хувьд жигдлэх асар том зорилт тавьж байна. Үүний тулд улсын төсвөөс их хэмжээний хөрөнгө зардал гаргах хийгээд Шэньчжэн, Шанхай зэрэг газруудаас санхүүгийн дэмжлэг авах мөн олон улсын зээл тусламжийг өргөнөөр ашиглахаар төлөвлөж байна. Хэдийгээр ӨМӨЗО нь газар зүйн хувьд тус бүсэд байрладаггүй ч гэсэн эдийн засгийн бүсчлэлийн хувьд тус бүсэд хамрагдаж байна. Ийнхүү Хятад улс зах хязгаарын хийгээд хил орчмын бүс нутгийг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлж байгаа энэхүү нөхцөлд манай улсын хилийн боомт болох Замын-Үүдийн ойролцоо эдийн засгийн чөлөөт бүс байгуулах таатай нөхцөл бүрэлдээд байна гэж хэлж болох талтай. Иймээс энэхүү таатай нөхцөлийг аль болохоор оновчтой, зөв ашиглах шаардлага аяндаа гарч байгаа юм. Чингэхдээ хэрэв Хятадын тал эдийн засгийн чөлөөт бүсийн нэг хэлбэр болох худалдааны чөлөөт бүс байгуулах тохиолдолд манай тал Замын-Үүд хавийн бүс нутгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, экспортын баазыг өргөтгөх шаардлага урган гарч, манай улсын хувьд үйлдвэрлэл голлосон экспорт-үйлдвэрлэлийн эдийн засгийн бүс байгуулах нь илүү оновчтой мэт. Ер нь чөлөөт бүс байгуулах нь хялбар зүйл биш бөгөөд Хятадын туршлагаас харахад эх газар тухайлбал автономит районд байгуулагдсан эдийн засгийн чөлөөт бүсүүд нь далайн эрэг хавийн нутагт байгуулагдсан чөлөөт бүсүүдтэй харьцуулахад далайц, хөгжлийн хурдцын хувьд хязгаарлагдмал тал ажиглагдаж байна. Тухайлбал ӨМӨЗО –ы төв Хөх хотын 4 талд байгуулагдсан чөлөөт бүсүүдээс нэлээд амжилттай хөгжиж байгаа нь “Или”-гийн сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр хийгээд “Лу ван” ноолуурын үйлдвэр үйл ажиллагаагаа явуулж буй чөлөөт эдийн засгийн бүс юм. Ийнхүү чөлөөт бүс байгуулахад маш нарийн судалгаа, экспертиз шаарддаг бөгөөд “Экспортын бүс байгуулах дэлхийн ассоциаци” зэрэг нь энэ төрлийн судалгаа хийдэг байна. Мөн Хятад улстай хамтран эдийн засгийн чөлөөт бүсийн аль хэлбэр нь манай улсад илүү тохиромжтойг судалж болох мэт.

Ийнхүү хил орчмын худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаа нь төвөөс алслагдсан бүс нутгийг хөгжүүлэх бололцоог нээх, улсын төсөвд нэмэлт орлого оруулах чухал суваг бөгөөд үүнийг оновчтой ашиглахын тулд төр засгаас маш нарийн судалгаа олон талт бодлого шаардагдаж байна.

Ашигласан материал:

1. Сю Бочжан. ХКН-ын “Аюулгүй байдлын шинэ үзэл баримтлал ба “эдийн засгийн аюулгүй байдлын талаархи дүн шинжилгээ” ХКН-ын талаархи судалгаа сэтгүүл, 2004 оны 11-р сарын 25 N•11 /Тайвань/
2. Баатар. “Хятад, Монголын хилийн худалдааны чөлөөт бүс байгуулах тухайд. “Эрдэм шинжилгээний өгүүллүүдийн түүвэр. Хөххот, 2004
3. Б.В.Базаров, Д.В.Ганжуров. Российско-китайские отношения и роль регионов Восточной Сибири в их развитии. Иркутск. 2002
4. Н.Н.Нырова, Некоторые особенности Российско-китайской приграничной торговли (опыт и размышления) Веб сайт- allchina.ru
5. А.Тарасов. Торговые связи Забайкалья с Китаем. ПДВ. 2004 N•3